



## Шатрын зохиомжийн дэлхийн өдөрт

Шатарт урлагийн элементийг шингээдэг комбинацийн санаануудыг уран сайхны хэлбэрээр илэрхийлдэг бүтээлч үйл ажиллагаа нь **шатрын зохиомж (композици)** юм.

Хүн төрөлхтний бүтээсэн дуу хөгжим, бүжиг, зураг уран зохиол зэрэг ахуйн шинжтэй урлагийн уламжлалт төрлүүдтэй харьцуулбал шатрын зохиомж нь ердөө л ганцхан мянганы өмнө үүссэн, сэтгэхүйн чиглэлийн урлагийн шинэ залуу төрөл боловч өндөр соёл иргэншил, өргөн мэдээлэлтэй улс орнуудад түргэн дэлгэрч өнгөрсөн зууны сүүлчийн хагаст хэлбэр, агуулга нь баяжин хөгжлийн шинэ шатанд гарчээ.

ОУШХ-ны (FIDE) дэргэдэх Шатрын Зохиомжийн Байнгын Комисс (РССС) нь 39 гишүүнтэй (Монгол улс 1988 онд 22 дахь гишүүнээр нь элссэн), **Зохиогчдын** болон **Бодогчдын** Дэлхийн багийн ба хувийн аварга шалгаруулах тэмцээн зохиох, шилдэг бүтээлийн цомог гаргах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Дээрх төрлүүдээр ИМ, ОУМ ба ФМ цолтон 500, дэлхийн чансаатай бодогчид 700 гаруй байдаг.


2007 оны 10-р сард Грек улсад хуралдсан РССС-ийн **50 дахь чуулганаас** шатрын зохиомжийг сурталчлан хөгжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байгаа Монголын зохиогч **С.Чимэдцэрэнд “Хүндэт мастер”** цол хүртээсэн юм. (Шатрын зохиомж нь манай оронд 40 шахам жилийн өмнөөс дэлгэрсэн бөгөөд спортын энэ төрлөөр ОУХМ-3, СМ-2 ба ДМ цолтон 4 байна)

Энэ чуулган дэлхийн 2006 оны шилдэг этюдээр **Юрий Базловын (ОХУ)** бүтээлийг шалгаруулжээ.

### Бентийн дурсгалын уралдаан

I хүндэт үнэлгээ

Ю.Базлов 2006



хожил 4+5

1. ♖e4+ (1. ♜e4+? ♜c5 2. ♖:c4 ♖f4+ 3. ♜g6 ♜:c4 4. ♜a8 ♜e7=)  
1... ♜e6 2. ♜c5! (2. ♜b3? ♜f4 3. ♜:a4 ♜:e4 =) 2... ♖f4+ (2... ♜fa7  
3. ♖d5+ ♜f5 4. ♜f8+ ♜g4 5. ♜f3+ ♜h4 6. ♖e6) 3. ♜g6 ♜e5+ 4. ♜h5  
♜:e4 (4... ♜d7 5. ♖d5+ ♜:d5 6. Sc7+ ♜d7 (♜f5) 7. ♜:d5 хожно;  
4... ♜fa7 5. ♖d5+ ♜d7 6. ♜f6+ ♜d8 7. ♖e6 ♜4a5 8. ♜b6+ ♜e7  
9. ♜g8+ ♜f8 10. ♜d8+ ♜g7 11. ♜f6+ ♜h7 12. ♜e7 хожно) 5. ♜d6+  
♜f5 6. ♜f6+!! ♜:f6 7. ♜g7 мад!

Одоогоос 140 шахам жилийн тэртээ Чехийн зураач **Антонин Кениг** “Шатрын бодлого нь урлагийн бүтээл мөн” хэмээн “Светозор” сэтгүүлд анх тунхагласныг үндэслэн РССС –ийн 50-р чуулганаас **жил бүрийн нэгдүгээр сарын 4-нд Шатрын зохиомжийн олон улсын өдрийг** тэмдэглэж байх шийдвэр гаргажээ.

Шатрын зохиомжийн ОУХМ Л.Тогоохүү